



**МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2021 оны 11 сарын 19 өдөр

Дугаар А/703

Номгон


**Мотоциклийн хөдөлгөөнийг түр хориглох
тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.а, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүйтний улирал эхэлж, аймгийн хэмжээний авто замын зорчих хэсгийн гадаргуу цасан давхарга тогтон халтиргаа гулгаа үүсч авто замын нөхцөл байдал хүндрэхтэй холбогдуулан замын хөдөлгөөнд оролцогчдыг осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, учирч болох хор хохирол, эрсдэлийг бууруулах, аюулгүй байдлыг хангуулах зорилгоор аймгийн нийт нутаг дэвсгэрт 2021 оны 12 дугаар дугаар сарын 01-ний өдрөөс 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд мотоциклоор замын хөдөлгөөнд оролцохыг хориглосугай.

2.Захирамжийг олон нийтэд мэдээлэх, илэрсэн зөрчлийг арилгуулах, хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх анхааруулга, таниулга хийх ажлыг олон нийтийн хэрэгслээр сурталчлан ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (Д.Сарангарав)-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН